



НИСЛЭГ ТЕХНИКИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ  
ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБАНЫ ДАРГЫН  
ТУШААЛ

2020 оны 02 сарын 19 өдөр

Дугаар А/01

Улаанбаатар хот

Хариуцлагатай жижүүр томилох тухай

“Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүд, тэдгээрийг тэмдэглэн өнгөрүүлэх тухай” хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.9-д заасны дагуу Цагаан сарын баярын өдөр бүх нийтээрээ амрахтай холбогдуулан 2020 оны 02 дугаар сарын 22-ны өдрөөс 26-ны өдрийг хүртэлх 5 хоногийн хугацаанд хариуцлагатай жижүүр томилох зорилгоор ТУШААХ нь:

1. Цагаан сарын баярын өдрийг тохиолдуулан нийтээр амрах баярын өдрүүдэд Нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албанаас ажиллах хариуцлагатай жижүүрийн ажлын удирдамжийг нэгдүгээр хавсралтаар, хуваарийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Баярын өдрүүдэд үндсэн үүрэгт ажил болон нислэг техникийн осол, зөрчлийн талаар дүрмийн дагуу мэдээ, мэдээллээр хангахыг хариуцлагатай жижүүрт үүрэг болгосугай.
3. Баярын өдрүүдэд ажилласан хариуцлагатай жижүүрт хяналт тавьж ажиллах, энэ хугацаанд гарсан мэдээ, мэдээллийг нэгтгэж танилцуулахыг Нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны ахлах шинжээч Х.Наранхүүд даалгасугай.

АЛБАНЫ ДАРГА БӨГӨӨД  
ЕРӨНХИЙ ШИНЖЭЭЧ



Ж.ЦОЛМОН



НИСЛЭГ ТЕХНИКИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ  
ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБАНЫ ДАРГЫН  
ТУШААЛ

2020 оны 03 сарын 03 өдөр

Дугаар

A/02

Улаанбаатар хот

Зөвлөмжийн биелэлтийн тухай

ИКАО-ын Хавсралт 13-ын 6 дугаар бүлгийн 6.8 дахь заалт, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018.08.09-ний өдрийн 171 дугаар тушаалаар баталсан Нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны дүрмийн 4.4.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Шинжлэн шалгах ажиллагааны тайланд үндэслэн осол, зөрчил давтагдан гарахаас урьдчилан сэргийлэх зорилгоор гаргасан аюулгүй ажиллагааны зөвлөмжийн биелэлтийг холбогдох байгууллагуудаас улирал бүр авч дүгнэн, Зам, Тээврийн хөгжлийн сайдад хүргүүлж, танилцуулж байхыг ахлах шинжээч /Х.Наранхүү/-д даалгасугай.

2. Зөвлөмж өгөгдсөн байгууллагаас зөвлөмжийн дагуу авсан арга хэмжээний талаар ирүүлэхийг шаардах, хариуцсан хүмүүстэй нь уулзалт, ярилцлага хийх үед протокол хөтлөн, баримтжуулж байх, албаны цахим хуудсаар танилцуулж байхыг бүртгэл, судалгааны мэргэжилтэн /С.Баттулга/-д даалгасугай.

АЛБАНЫ ДАРГА БӨГӨӨД  
ЕРӨНХИЙ ШИНЖЭЭЧ



*Ж.Цолмон*

Ж.ЦОЛМОН



НИСЛЭГ ТЕХНИКИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ  
ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБАНЫ ДАРГЫН  
ТУШААЛ

2020 оны 07 сарын 02 өдөр

Дугаар А/03

Улаанбаатар хот

Шинжлэн шалгах багийг томилох тухай

Иргэний нисэхийн тухай Монгол улсын хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.4 Чикагогийн конвенцийн 13 дугаар хавсралтын 5.1, Иргэний нисэхийн багц дүрэм 203-ын 8.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. МИАТ компанийн EI-CXV бүртгэлийн дугаартай В737-800 маягийн агаарын хөлөг 2020 оны 07 дугаар сарын 02-ны өдөр Сөүл-Улаанбаатарын чиглэлд нислэг үйлдэж байх үед зүүн хөдөлгүүр унтарсан ноцтой зөрчлийг шинжлэн шалгах багийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай. Үүнд:

Шинжлэн шалгах багийн ахлагч:

Х.Наранхүү, Нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны ахлах шинжээч

Гишүүд:

О.Бат-Орших, Нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны шинжээч

И. Энхчулуун, Нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны шинжээч


Я. Энхбаяр, Нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны шинжээч

П. Гэрэлчимэг, Нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны бичлэг тайлах мэргэжилтэн

Б. Чинзориг, Изинис Эйрвэйз ХХК-ний техникийн захирал, В737 агаарын хөлгийн инженер /эксперт/

2. Шинжлэн шалгах ажиллагааг Чикагогийн конвенцийн 13 дугаар хавсралт, албаны "Aircraft Accident Investigation Policy and Procedures Manual"-ын дагуу хийж гүйцэтгэхийг багийн ахлагч (Х.Наранхүү)-д үүрэг болгосугай.

АЛБАНЫ ДАРГА БӨГӨӨД  
ЕРӨНХИЙ ШИНЖЭЭЧ



Ж.ЦОЛМОН



НИСЛЭГ ТЕХНИКИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ  
ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБАНЫ ДАРГЫН  
ТУШААЛ

2020 оны 07 сарын 09 өдөр

Дугаар А/04

Улаанбаатар хот

Хариуцлагатай жижүүр томилох тухай

“Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай” хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д заасны дагуу Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын ойн баярын өдрүүдэд 2020 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн 17.00 цагаас эхлэн 2020 оны 07 дугаар сарын 16-ны өдрийн 08.00 цаг хүртэлх хугацаанд хариуцлагатай жижүүр томилох зорилгоор ТУШААХ нь:

1. Ардын хувьсгалын 99 жилийн ойн баяр наадмын нийтээр амрах баярын өдрүүдэд Нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албанаас ажиллах хариуцлагатай жижүүрийн ажлын удирдамжийг нэгдүгээр хавсралтаар, хуваарийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Баярын өдрүүдэд үндсэн үүрэгт ажил болон нислэг техникийн осол, зөрчлийн талаар дүрмийн дагуу мэдээ, мэдээллээр хангахыг хариуцлагатай жижүүрт үүрэг болгосугай.
3. Баярын өдрүүдэд ажилласан хариуцлагатай жижүүрт хяналт тавьж ажиллах, энэ хугацаанд гарсан мэдээ, мэдээллийг нэгтгэж танилцуулахыг Нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны ахлах шинжээч Х.Наранхүүд даалгасугай.

АЛБАНЫ ДАРГА БӨГӨӨД  
ЕРӨНХИЙ ШИНЖЭЭЧ



Ж.ЦОЛМОН